

2. Хороод Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дах заалтын дагуу нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг их цэвэрлэгээний ажилд татан оролцуулах, цэвэрлэгээний талаарх мэдээллийг байгууллага аж ахуйн нэгж, иргэдэд шуурхай хүргэх, томоохон зах худалдаа үйлчилгээний төвүүдийг түр хугацаагаар хааж, түрээслэгч болон худалдааны төвийн ажилтнуудыг цэвэрлэгээнд хамруулах;

3. Цэвэрлэгээг хийхдээ аж ахуйн нэгж, байгууллага ойр орчны 50м газрын, сууц өмчлөгчдийн холбоод орц болон хариуцсан газрын хог хаягдлын цэвэрлэгээ хийж, гэрэлтүүлгийг бүрэн асаах, үерийн хамгаалалт, барилга байгууламж, ус хуримтлагддаг гуу жалга, ус нэвтрүүлэх хоолойд хуримтлагдсан ахуйн гаралтай хог хаягдлыг оршин суугчдын оролцоотойгоор цэвэрлэх;

4. Их цэвэрлэгээнд оролцохдоо бээлий, хүрз, шүүр болон бусад багаж хэрэгслийг өөрсдөө бэлтгэн оролцоно;

Цэвэрлэгээний ажилд хяналт тавих:

Бүх нийтийн их цэвэрлэгээнд Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газар хяналт тавьж ажиллана.

Цэвэрлэгээний ажлыг сурталчилах:

Бүх нийтийн их цэвэрлэгээг иргэдэд зарлах, сурталчилах, ажлын явц байдлыг хэвлэл мэдээллийг хэрэгслээр тухай бүр сурталчлан ажиллана.

Ажлын дүнг гаргах:

Хороод цэвэрлэгээ хийсэн тайлан мэдээг 2017 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 17 цагаас өмнө фото зургаар /цэвэрлэгээний өмнөх болон дараах гэсэн харьцуулалттай/ баталгаажуулан, файлаар хүснэгтэн мэдээллийн хамт bzd.dedbutets@gmail.com хаягаар ирүүлэх бөгөөд нэгдсэн дүн мэдээг Нийслэлийн Шуурхай Удирдлага Зохицуулалтын төв болон Захирагчийн ажлын албанд хүргүүлнэ. Мэдээг хоцроосон, худал мэдээлэл ирүүлсэн байгууллагыг бүх нийтийн их цэвэрлэгээг хангалтгүй зохион байгуулсанд тооцно. Идэвхгүй оролцсон хороод, сууц өмчлөгчдийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллагад Хог хаягдлын тухай хуульд заасан арга хэмжээ авна.

Жич: Хяналт тавих хэлтэс, албадууд нь хариуцсан хороодтой хамтран ажиллах, цэвэрлэгээний явц байдлын талаар илтгэх хуудас ирүүлэх.

Утас: 51266579 99278448 А.Монголжингоо